



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/21

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 3/02 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Монгол орноо төдийгүй дэлхий дахинд нүүдэлчний соёл, өв уламжлалыг сурталчлах зорилготой 1000 км зайг 9 хоногт туулах “Дэлхийн морьтонгууд” төслийн “Морин өртөө” уралдаанд Ховд аймгаас оролцох Мянгад сумын Н.Мягмаржавын зардлын дэмжлэгт 3 000 000 төгрөгийг зарцуулсугай.

2.Зардалд зарцуулагдах 3 000 000 төгрөг / гурван сая /-ийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалтын 4.4-д тусгагдсан “Спортын аварга” арга хэмжээнээс санхүүжүүлэхыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Б.Даваадорж/ нарт тус тус зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ